



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/407


Ховд

Шүүхийн шийдвэртэй өр барагдуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралын 2022 оны "Аймгийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай" 7/02 дугаар тогтоол, Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 154/ШШ2022/00106, 154/ШШ2022/00109, 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 154/ШШ2022/00110, 154/ШШ2022/00107 дугаартай захирамжийг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсөвт байгууллагуудад дулаан халаалтын үйлчилгээг үзүүлж буй хувийн хэвшлийн байгууллагуудын эрх бүхий байгууллагаас баталсан төлбөрийн үнэлгээгээр тооцсон халаалтын хөлс болон дулаан ашиглагч төсөвт байгууллагуудын жил бүрийн халаалтын батлагдсан төсвийн зөрүүгээс үүссэн Алтай сумын төсөвт байгууллагуудаас "Тоосгон уул" ХХК-д төлүүлэх өрийн тухай Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн 453,117,274.00 төгрөг (дөрвөн зуун тавин гурван сая нэг зуун арван долоон мянга хоёр зуун далан дөрөв)-ийг хавсралтаар баталж халаалтын өрийг барагдуулахаар зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 453,117,274.00 төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд 2022 онд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2242
Zah A7407 tum



Аймгийн Засаг даргын 2022 оны
06 дугаар соёлын 9-ны өдрийн
А/407 дугаар захирамжийн Хялсаалт

**АЛТАЙ СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН
ХАЛААЛТЫН ӨРИЙГ БАРАГДУУЛАХ ЖАГСААЛТ**

Д/д	Хүлээн авах байгууллагын нэр	Шүүхийн шийдвэрийн он сар, өдөр, дугаар	Төлбөр тооцогдох он, сар	Нийт дүн / төгрөгөөр/
1.	Алтай сумын эрүүл мэндийн төв	2022.05.13 №154/ШШ2022/00110	2020 оны 01,02, 03,10, 2021 оны 1-4 сар	21,309,500.00
2.	Алтай сумын ЕБСургууль	2022.05.13 №154/ШШ2022/00107	2020 оны 01,02, 03,10,11,12, 2021 оны 1-4	352,934,967.00
3.	Алтай сумын хүүхдийн цэцэрлэг	2022.05.12 №154/ШШ2022/00106	2019-02-12 сар, 2020 оны 01-12 сар, 2021 оны 01-12сар	23,890,712.00
4.	Алтай сумын соёлын төв	2022.05.12 №154/ШШ2022/00109	2019, 2020, 2021 он	54,982,095.00
	Дүн			453,117,274.00